



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 4/152.

Хэрлэн сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт байгаа мал, амьтныг халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, паразиттах өвчинөөс эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалт, лабораторийн шинжилгээнд хамруулах, ариутгал халдвартгүйтгэл хийх зэрэг төлөвлөгөөт арга хэмжээг 2019 оны 10 сарын 01 хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал амьтныг халдварт, паразиттах өвчинөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тандан шинжлэх, оношлох, халдвартгүйтгэх арга хэмжээнд шаардагдах эм урвалж, биобэлдмэл, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай зохион байгуулж малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж, хүн хүч, тээврийн хэрэгслээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бий болгосон малчин, мал бүхий иргэд, холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т хариуцуулсугай.

4. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга, оношлогоо, шинжилгээ, халдвартгүйтгэлийн гүйцэтгэлд хяналт, шалгалт хийхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсвийн Мал эмнэлгийн тарилгын үйлчилгээний хөлсний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, гүйцэтгэлийг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга /Н.Анхбаяр/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

